

**“ЖЕНДЕРТ СУУРИЛСАН БОЛОН ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ”
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/2025 оны жилийн эцсийн байдлаар/**

Орхон аймгийн Эрүүл мэндийн газар

2025 оны 12 дүгээр сарын 30

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	2025 онд Хүрэх түвшин	Төсөв		Хүрсэн түвшин (биелэлт)	Хэрэгжилт ийн хувь
			Зарцуулсан төсөв	Эх үүсвэр хаанаас		
Зорилго: Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх, хүчирхийлэлд өртсөн хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах						
Зорилт 1. Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрх зүйн орчныг сайжруулах;						
1.1	Жендерт суурилсан хүчирхийлэл, эрүүл мэндийн салбарт дахь хүүхэд хамгаалал, гэр бүлийн тухай, хууль эрх зүйг сурталчлах, арга зүйгээр хангах	Хууль эрх зүйг сурталчлан танилцуулна.	-	-	Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - Тайлант хугацаанд Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам, хүүхэд хамгааллын тухай хууль болон хүүхэд хамгааллын талаар гарсан эрх зүйн баримт бичгүүдийн талаар 2 удаагийн чиглэл, мэдээлэл сургалтыг зохион байгуулж, тус сургалтад 95 сум, өрхийн эрүүл мэндийн төв эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтныг хамруулж чадавхжуулан арга зүйгээр хангаж ажилласан. - Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүний эрхийн тухай ярилцъя хурал, уулзалтад хамтран оролцож, хүүхдийн тэргүүлэх өвчлөл, хүүхэд хамгаалал, хөгжлийн чиглэлээр тулгамдсан асуудлуудыг хэлэлцсэн.	70
1.2	Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний дараа үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах ажлыг зохион байгуулах	Хүчирхийлэлд өртсөний дараа үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирсан байна.	-	-	Тайлант хугацаанд түр хамгаалах байранд 61 хүүхэд, 8 насанд хүрэгч буюу нийт 69 хүн жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний улмаас түр хамгаалах үйлчилгээнд хамрагдсан байна. Үүнээс 11 хүүхдэд шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж ажилласан байна. 2025 оны байдлаар БОЭТ-ийн Хүлээн авах хэсгээр осол гэмтэлд өртсөн 5192 иргэн ирсэн бөгөөд үүнээс хүчирхийлэлд өртсөн 175 эмэгтэй, 30 хүүхдэд яаралтай тусламжийг үзүүлсэн. Үүнээс 10 эмэгтэй, 6 хүүхдийг эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн ба 5 эмэгтэй, 5 хүүхдэд мэс	70

					заслын, 20 эмэгтэй, 3 хүүхдэд эмийн эмчилгээ хийгдэж, 45 эмэгтэй, 40 хүүхэд амбулаторийн хяналтад эмчлэгдсэн байна.	
1.3	Хүчирхийллийн хохирогчдод шаардлагатай өндөр өртөгтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг холбогдох байгууллагатай зөвшилцөн тусламж, үйлчилгээг үзүүлэх	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.	-	-	Хүчирхийллийн хохирогчдод шаардлагатай өндөр өртөгтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг оношийн хамааралтай бүлгээр ЭМД-аас нэхэмжлэн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Хүчирхийллийн хохирогчид шаардлагатай өндөр өртөгтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.	100
1.4	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг ханган ажиллах	Гамшгийн үеийн бэлэн байдал, тусламж үйлчилгээ сайжирсан байна.	-	-	Баян-Өндөр сумын ЗДТГ, Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран малчдад эрүүл мэндийн үзлэгийг Баян-Өндөр суманд 9 чиглэлд, Жаргалант суманд 6 чиглэлд нийт 15 чиглэлд хуваарийн дагуу явуулаар хүргэж байна. Баян-Өндөр сумын 9 чиглэлд эмч, эмнэлгийн мэргэжилтэн мал, тэжээвэр амьтдын тооллогын багт ажиллан 188 өрхийн 548 иргэнд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэн эрсдэлт бүлгийн иргэдийн 301 хүний судалгааг нэгтгэн шинэчилж 35-120 км-т үйлчлэх хүрээний радиусыг тогтоон зураглал гаргасан. Сэтгэцийн эрүүл мэндийн Дэлхийн өдөр нь 2025 онд Гамшгийн үеийн сэтгэл зүй уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлсэн ба энэ өдрийг тохиолдуулан Төрийн болон Төрийн бус 16 байгууллагатай хамтран “Сэтгэцийн Эрүүл Мэндийн Өдөрлөг”-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Соёл урлагийн цогцолборт амжилттай зохион байгуулж давхардсан тоогоор 1800 иргэн хамрагдсан. Соёл урлагийн цогцолборын их танхимд үдээс өмнө 4 төрлийн, үдээс хойш 5 төрлийн Сэтгэл зүйн сургалтууд зохион байгуулагдаж, задгай зааланд Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын 11 өртөө ажиллаж иргэдэд сэтгэл зүйн чиглэлийн мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгч, оношилгоо хийж ажилласан.	80
1.5	Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах	Эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээнд холбон зуучилна.	-	-	Баян-Өндөр сумын хүүхэд хамгааллын хамтарсан баг 4 удаа хуралдаж, эцэг эх нь архины хамааралтай, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 6 тохиолдлыг хэлэлцэж шийдвэрлэн холбогдох байгууллагуудтай хамтран	100

	ажлыг зохион байгуулах				ажиллаж, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх тасаг, эмэгтэйчүүдийн эмч, сэтгэцийн эмч нартай холбон зуучилж, мэдээллийг хүргэж шаардлагатай эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн. Өсвөр үеийн кабинетад насанд хүрээгүй өсвөр насны 3 жирэмсний тохиолдлын мэдээллийг шуурхай солилцож хурлаар хэлэлцүүлэн харьяаллын өрхийн эмч болон БОЭТ-н төрөх тасаг БЗДХ-н кабинет, сэтгэлзүйч, хүүхэд хамгааллын багтай хамтран тусламж үйлчилгээ үзүүлсэн. Тайлант хугацаанд хамтарсан 26 багт нийт 251 кейс бүртгэгдэж үүнээс 203 тохиолдол дээр кейс менежментийн зарчим, алхмын дагуу хамтарсан багийн гишүүд уялдаа холбоотой ажиллаж шийдвэрлэсэн байна. Тайлант хугацаанд эцэг, эх асран хамгаалагчдын үл хайхрах, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 112 хүүхдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үйлчилгээ үзлэг, оношилгоонд хамруулсан байна. ӨЭМТ-ийн эмч нар гэрийн эргэлт, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоогоор эрсдэлт нөхцөлд буй эрх нь зөрчигдсөн 15 хүүхдийг илрүүлж мэдээлсэн.	
Зорилт 2. Жендерт суурилсан хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийллийн нөлөөллийн талаарх тандалт судалгаа, статистик бүртгэлийн боловсронгуй болгож, нэгдсэн мэдээллийн сан байгуулах;						
2.1	Ажлын байран дээрх жендерт суурилсан хүчирхийллийг судлах	Ажлын байран дээрх жендерт суурилсан хүчирхийллийг судалсан байна.			Тайлант хугацаанд Жендэрийн хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангах хүрээнд ЭМБ-уудын хөдөлмөрийн дотоод журамд 100% нэмэлт өөрчлөлт оруулж, хөдөлмөрийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, ажлын байранд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлийг ЭМБ-уудын удирдлагууд өгч ажилласнаар тайлант хугацаанд гэмт хэргийн зөрчил, ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, хүний эрхийг зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй байна	70
2.2	Эрүүл мэндийн үйлчилгээнд үйлчлүүлэгчийн бэртэл, гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, зан үйлийн өөрчлөлтийн	Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэнэ.			Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар гэрийн эргэлт, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоогоор эрсдэлт нөхцөлд буй эрх нь зөрчигдсөн, үл хайхрах, бэлгийн хүчирхийлэлд өрсөн байж болзошгүй 15 хүүхдийг илрүүлж ХГБХХГ, ЦГ, хамтарсан багт мэдээлж тусламж үйлчилгээ үзүүлж хамтран ажилласан.	100

	шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах, илрүүлэх				Тайлант хугацаанд хамтарсан 26 багт нийт 251 кейс бүртгэгдэж үүнээс 203 тохиолдол дээр кейс менежментийн зарчим, алхмын дагуу хамтарсан багийн гишүүд уялдаа холбоотой ажиллаж шийдвэрлэсэн байна. Тайлант хугацаанд эцэг, эх асран хамгаалагчдын үл хайхрах, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 112 хүүхдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үйлчилгээ үзлэг, оношилгоонд хамруулсан байна.	
2.3	Нийгмийн эрүүл мэндэд хүчирхийллийн үзүүлж буй нөлөө, осол, гэмтэл өвчлөлийн шалтгааныг судлах, урьдчилан сэргийлэх	Хүчирхийлэлд нөлөөлж буй шалтгааныг судална.	-	-	Аймгийн хэмжээнд 2025 оны эхний 11 сарын байдлаар осол гэмтлийн өвчлөлийн 905 тохиолдол бүртгэгдэж 10 000 хүн амд 85.1 промилл байгаагаас 71 тохиолдол буюу 7.8 хувийг биеийн хүч хэрэглэн бусдад халдсан тохиолдол эзэлж байна. Эдгээр 71 тохиолдлын 69-ыг эрэгтэй, 2 тохиолдлыг эмэгтэй хүн үйлдсэн байна. Тус биеийн хүч хэрэглэн бусдад халдсан тохиолдлын 33 тохиолдлыг танил, 20 тохиолдлыг үл таних хүн, 8 тохиолдлыг гэр бүлийн хүн, хамтран амьдрагч, 5 тохиолдлыг бусад, 4 тохиолдлыг тодорхойгүй, 1 тохиолдлыг бусад хамаатан эзэлж байна.	80
2.4	Жендерт суурилсан хүчирхийлэл амиа хорлох, архиан согтуурах, мансуурах гэх мэт зуршлын харилцан хамаарлыг судлах, хариу арга хэмжээ авах	ЖСХ амиа хорлох, донтох эмгэгт өртөх шалтгааныг судалсан байна.	-	-	- Эрдэнэт клиникийн сэтгэцийн кабинетаар 1960 хүн үйлчилгээ авч, идэвхтэй хяналтанд байсан 42, эдгэрсэн 35 үйлчлүүлэгч байсан. 52 удаагийн сургалтад “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 3487 ажилтан, аутотренингд 620 хүн хамрагдсан байна. - БОЭТ-ийн Сэтгэц-наркологиын тасагт 579 хүн хэвтэн эмчлүүлсэн. Үүнээс: F10 бүлэг буюу архины хордлого оношоор 177, Сэтгэцийн эмгэгийн бусад оношоор 402 хэвтэн эмчлүүлэгчид хэвтэн эмчлүүлсэн. Тасаг нь Хөдөлмөр засал, ном, хөгжим, арт терапи зэрэг заслын эмчилгээ хийж ажилладаг. - Сэтгэц наркологиын “Оюу” эмнэлэгт нийт 441 хүн хэвтэн эмчлүүлсэнээс 257 хүн нь архины хордлого тайлах эмчилгээ хийлгэсэн. Хэвтэн эмчлүүлэгчид сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилладаг. - Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтаас амиа хорлолт 2 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс нэмэгдээгүй байна. - Архидан согтуурах, мансуурах, донтох эмгэгээс сэргийлж ӨЭМТ-үүд нь өөрийн пэйж хуудсаараа 74	90

					удаагийн цахим хуудсаар дамжуулан цахим залилан, архи, тамхи мансуурах бодис, сэтгэлзүйн чиглэлээр мэдээлэл оруулж 82800 иргэнд хүргэсэн байна. Мөн мансууруулах бодис буюу тамхинаас гарах цаасан зөвлөгөөг 70 иргэнд хүргэсэн. - Тамхины тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Эрдэнэт сувиллын цогцолборын сэтгэл засалч эмчийн хяналтанд 126 ажилтан байснаас 38 хүн тамхинаас гарсан. 29 хүн эмийн эмчилгээ хийлгэж байна. Өрхийн эмнэлгийн хяналтанд 48 иргэнд тамхинаас гаргах чихний зүү эмчилгээг хийж 13 иргэн тамхинаас гарсан 28 иргэн тамхины бага хамааралтай болсон.	
2.5	Гэрийн асаргаанд байдаг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүчирхийллийн хохирогч болохоос сэргийлэх, эрт илрүүлэх	Гэрийн асаргаанд байдаг иргэний судалгааг гаргах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан байна.	-	-	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны “Журам батлах тухай” А/28, А/27 дугаар тушаалын дагуу Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн бүрэлдэхүүн, багийн 2025 оны төлөвлөгөөг Орхон аймгийн Засаг даргын 2025 оны А/554 дугаар захирамжаар баталж, багийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын НБХ, ЭМГ, ХХҮГ, Ахмадын хороо хамтран ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээг мэргэжил аргагүйгээр ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нарыг чадавхжуулах сургалтыг 2 удаа 55 эмчийг хамруулан зохион байгуулж, Орхон аймгийн 2 сум, 29 багийн хүрээнд 1510 ахмадын цогц үнэлгээг хийн ажиллаа. Ахмад настны цогц үнэлгээнд сэтгэл гутрал, хоол тэжээлийн доройтол, нийгмийн халамж хэрэгцээтэй настанд үзүүлэх тусламж үйлчилгээг илрүүлэх, эрх бүхий аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад холбон зуучилна гэж заасан байдаг бөгөөд 3-р түвшний байнгын асаргаа шаардлагатай 36 ахмад настанг багийн зохицуулагч, нийгмийн халамжийн ажилтны хамт хамтарсан үнэлгээ хийсэн. Аймгийн хэмжээнд хөнгөвчлөх, гэрийн тусламж үйлчилгээ авдаг 912 ахмад байгаа ба давхардсан тоогоор 4137 удаа гэрийн тусламж үйлчилгээ авсан байна. Аймгийн хэмжээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвд 4-р бүлэг-2044, 5-р бүлэг-183 буюу 2227 иргэн хяналтад байна. Гэрийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд нийт 523 иргэн хамрагдаж, уламжлалт эмчилгээ, сэтгэл зүйн	100

					эмчилгээтэй хавсран үзүүлснээр эмчилгээний үр дүн 0.9%-иар нэмэгдсэн. Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Хавдар, хөнгөвчлөхийн тасагт 558 буюу хорт хавдар- 458, хоргүй хавдар-100 иргэнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, хими эмчилгээнд 657 иргэн хамруулсан.	
2.6	Энэрэл төвд амьдарч байгаа хүүхдүүдэд далд хэлбэрийн хүчирхийлэл үйлдэгдэж байгаа эсэхийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах	Далд хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.	-	-	Энэрэл асрамжийн төвийн бүтэц орон тоонд 1 эмч орон тоогоор дагнан ажиллаж, тус төвийн 18 хүртэлх насны 54 хүүхдийг эрүүл мэндийн хяналтад авч, өдөр тутмын хооллолт, бие бялдрын өсөлт хөгжлийн байдалд үнэлгээ хийж, эрүүлжүүлэх, өвчлөлөөс сэргийлэх арга хэмжээг авч ажиллаж байна. “Энэрэл асрамжийн төвийн хүүхдүүдэд эрүүл мэндийн үзлэг оношилгоог зохион байгуулан нийт 51 (94%) хүүхдийг чих хамар хоолой, нүдний эмч, хүүхдийн эмчийн үзлэг оношилгоо, шинжилгээнд хамруулж шаардлагатай хүүхдийг эхо, зүрхний цахилгаан бичлэг, MRI, рентген оношилгоонд бүрэн хамруулсан. Тус үзлэг оношилгоогоор амны хөндийн өвчлөл 19%, чих хамар хоолойн өвчлөл 66%, өсөлт хөгжлийн хоцрогдол 15 хувьд нь илэрсэн бөгөөд өвчтэй илэрсэн 46 хүүхдийг хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх зөвлөгөөг өгсөн байна.	90
2.7	Хүүхдийн байгууллагын багш ажилчдын зүгээс албан ажлын сэтгэлзүйн хэм, хэмжээг зөрчих, хүүхэдтэй тэгш бус харьцах, санаа бодлоо тулгах сөрөг нөлөөллийг тандах	Хүчирхийллийн нөлөөллийг тандсан байна.	-	-	- Ерөнхий боловсролын 24 сургуулийн 19 эмч, 29 нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургуулийн 22 сэтгэл зүйч сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. - Сургуулийн өмнөх боловсролын 38 цэцэрлэгт 2 сэтгэл зүйч, 20 эмч ажиллаж тусламж үйлчилгээ үзүүлж байна. Тайлант хугацаанд хамтарсан 26 багт нийт 251 кейс бүртгэгдэж үүнээс 203 тохиолдол дээр кейс менежментийн зарчим, алхмын дагуу хамтарсан багийн гишүүд уялдаа холбоотой ажиллаж шийдвэрлэсэн байна. Тайлант хугацаанд эцэг, эх асран хамгаалагчдын үл хайхрах, бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн хүчирхийлэлд өртсөн байж болзошгүй 112 хүүхдийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үйлчилгээ үзлэг, оношилгоонд хамруулсан байна. - Сэтгэцийн эрүүл мэндийн Дэлхийн өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан “Гамшгийн үеийн сэтгэл зүй”, “Уй гашууг даван туулах нь”, “Стресс	100

					менежмент” сургалтад сэтгэл зүйч, нийгмийн ажилтан эмч нар нийт 78 мэргэжилтэнг хамруулсан. Тайлант хугацаанд хүүхэдтэй тэгш бус харилцах, сэтгэлзүйн хэм, хэмжээг зөрчсөн тохиолдол илрээгүй байна. - СЭМҮТ-тэй хамтран Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Онцгой байдлын газар, Ерөнхий боловсролын сургуулийн сэтгэл зүйчдийг хамруулан “Тоглоомын хамаарлын сэтгэц-нийгмийн асуудал” сургалтыг зохион байгуулж 120 мэргэжилтэнг чадавжуулсан.	
Зорилт 3. Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй хүнийг илрүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;						
3.1	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээнд хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тусгана.	-	-	- Баян-Өндөр сум нь хамтарсан 26 багтай бөгөөд нийт салбар дундын 224 гишүүнтэй. Хамтарсан багийн гишүүдийн 28 буюу 12.5 хувьд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нар хамтран ажиллаж, эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн, салбар дундын уялдаа холбоог ханган ажиллаж байна. Анхан шатны тусламж үйлчилгээнд өсвөр үеийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгын хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах, далд хүчирхийллийг илрүүлэх, эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын чиглэлээр ажлын байранд чадавхжуулах 1 удаагийн сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн 7 төвийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, хамтарсан багаар ажиллах, мэдээллийг урсгалын дагуу шуурхай түгээх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, далд хүчирхийллийг илрүүлэх, таних, мэдээлэх, баримтжуулах талаар арга зүйн зөвлөмж өгч чадавхжуулсан. Өрхийн эрүүл мэндийн төвүүд “Ээжүүдийн клуб”-ын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж, 6-10 төрлийн сэдвийн хүрээнд 31 удаагийн сургалтад давхардсан тоогоор 979 жирэмсэн болон хөхүүл эхчүүд, бага насны хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулан	70

					эрүүл мэндийн боловсрол олгож эх, хүүхдийн эрүүл мэнд, асаргаа, хоол тэжээл, хөх арчилгаа, жирэмсний хяналтын ач холбогдлын талаар эрүүл мэндийн боловсрол олгож, тэдний мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн.	
3.2	Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх явцад хохирогчийг илрүүлэх, баримтжуулах, хамгаалах үйлчилгээ үзүүлэх сургалтыг зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байна.	-	-	Анхан шатны тусламж үйлчилгээнд өсвөр үеийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгын хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах, далд хүчирхийллийг илрүүлэх, эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын чиглэлээр ажлын байранд чадавхжуулах 1 удаагийн сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн 7 төвийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, хамтарсан багаар ажиллах, мэдээллийг урсгалын дагуу шуурхай түгээх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, далд хүчирхийллийг илрүүлэх, таних, мэдээлэх, баримтжуулах талаар арга зүйн зөвлөмж өгч чадавхжуулсан.	100
3.3	Хүүхэд өсвөр үе, оюутан залуучуудыг хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, зан үйлийн байдалд тандалт хийх	ЕБС-ын суралцагчдын хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэндийн байдалд тандалт хийсэн байна.	-	-	- Цагаан тоосны бүсэд амьдарч байгаа иргэдэд Эрүүл мэндийн боловсрол олгох 7 удаагийн өдөрлөгт сургуулийн өмнөх боловсролын байгууллага болон Ерөнхий боловсролын сургуулийн 566 хүүхдэд сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан. - “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” аян зохион байгуулагдаж нээлтийн арга хэмжээний сургалт хэлэлцүүлэгт Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 120 сурагчид хамрагдаж, тэдэнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, эрүүл мэндийн боловсролыг олон талт байдлаар олгосон. Тус аяны хүрээнд 8 сургуулийн 968 сурагчдад сэтгэл зүйн сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгч, 415 тараах материал тарааж ажилласан. - Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийнхан болон политехник коллежийн оюутнуудад ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, мансуурах зэрэг хорт зан үлээс сэргийлэх, хор уршгийн сургалтуудыг зохион байгуулж	80

					1952 өсвөр үеийнхэн хамрагдсан. - Орхон аймгийн хүүхдийн зөвлөлийн гишүүн, Эрүүл мэндийн газрын Сэтгэцийн эрүүл мэнд, , Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч хамтран Политехникийн коллежийн дотуур байранд хяналт хийж ажилласан. Хяналтын явцад ноцтой зөрчил гараагүй бөгөөд зөвлөн туслаж ажиллалаа. Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран ШШГГ-ын хяналтад байдаг 21 хүүхдэд “Эрүүл бус хүнсний хэрэглээ, Өсвөр насныханд зонхилон тохиолдох хоол боловсруулах замын эмгэг, хорт зуршил” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан. -ЕБ-ын 20-р сургуулийн 9-11 дүгээр ангийн 310 хүүхдийг хамруулан “Өсвөр насны сурагчдын сэтгэл гутрал, өөртөө итгэх итгэл, стрессийн түвшин болон цахим хэрэглээний” байдлыг судалсан. Тус судалгааны үр дүнд судалгаанд оролцогчдын найман сурагч тутмын тав нь өөртөө итгэлтэй, найман сурагч тутмын гурав нь өөртөө эргэлздэг, найман сурагч тутмын дөрөв нь сэтгэл гутралын дунд ба дундаас дээгүүр түвшинд байна. Хойд эцэг эхтэйгээ амьдардаг сурагчид төрсөн эцэг эхтэйгээ амьдардаг сурагчдаас илүү сэтгэл гутралд өртөх магадлал өндөр байна. Судалгааны үр дүнгээс харахад найман хүүхэд тутмын 6 нь цахим орчныг идэвхтэй ашигладаг ба цахим хэрэглээний хамааралд өртөх эрсдэлтэй гэсэн дүгнэлт гарсан байна.	
3.4	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг жендерт суурилсан хүчирхийллээс сэргийлэх ажлыг зохион байгуулах	Тусламж, үйлчилгээний хүртээмж сайжирна.	-	-	Тайлант хугацаанд 5 сургуулийн 439 охид болон үзлэгт хамрагдахаар ирсэн эмэгтэйчүүдэд “Хөхний хавдар, хөхөө өөрөө шалгах аргачлал”, “Өсвөр насны охид, хөвгүүдийн эрүүл мэнд”, “Гэр бүл төлөвлөлт, жирэмснээс хамгаалах арга хэрэгслүүд” зэрэг сэдвээр танхимын сургалт, цаасан брошур, ганцаарчилсан зөвлөгөөг нийт 1496 эмэгтэйд өгсөн байна. 8 өрхийн эрүүл мэндийн төв, 1 сумын эрүүл мэндийн төв үзлэгийг Амурлин Тэнгис ТББ, Мишээл НЦО, Хатагтай эмнэлгүүдтэй хамтран нийт 1496 (92.8%) эмэгтэйг үзлэг, оношилгоонд хамруулсан ба БЗДХ-ыг илрүүлэх шинжилгээнд 812 эмэгтэй, охидод зориулсан эхо	70

					оношилгоог 711 эмэгтэйд хийж, 192 (13%) эмэгтэйд өвчлөл илрүүлж, эмчилгээ, хяналтад авсан байна. Жирэмслэлтээс сэргийлэх арга (ЖСА) хэрэгсэл: Үзлэг хамрагдсан эмэгтэйчүүдэд ЖСА хэрэгслийг таниулах сургалт, зөвлөгөө өгч, шинээр 139 эмэгтэйд жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг тавив.	
3.5	Хүүхэд хамгааллын хамтарсан багт ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний ур, чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах	Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна.	-	-	Баян-Өндөр сум нь хамтарсан 26 багтай бөгөөд нийт салбар дундын 224 гишүүнтэй. Хамтарсан багийн гишүүдийн 28 буюу 12.5 хувьд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч нар хамтран ажиллаж, эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн, салбар дундын уялдаа холбоог хангаж байна. Анхан шатны тусламж үйлчилгээнд өсвөр үеийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгын хүрээнд эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулах, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулах, далд хүчирхийллийг илрүүлэх, эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын чиглэлээр ажлын байранд чадавхжуулах 1 удаагийн сургалтад сум, өрхийн эрүүл мэндийн 7 төвийн 56 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, хамтарсан багаар ажиллах, мэдээллийг урсгалын дагуу шуурхай түгээх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх, далд хүчирхийллийг илрүүлэх, таних, мэдээлэх, баримтжуулах талаар арга зүйн зөвлөмж өгч чадавхжуулсан.	100
3.6	Хүмүүсийн бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаа, интерсекс байдал, хүйсийн илэрхийлэл зэргээр ялгаварлан гадуурхалтыг хориглох, тусламж үйлчилгээг үр дүнтэй үзүүлэх эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг хандлагыг сайжруулах	Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд чадавхжуулах сургалт зохион байгуулсан байна.	-	-	Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд Өсвөр үеийн эрүүл мэнд хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох, чадавхжуулах сургалтыг 2 удаа сум, өрхийн эмч, сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудын 69 төлөөллийг хамруулан зохион байгуулсан. ЭМГ-аас хүүхэд, өсвөр үеийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 354 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, дунд ангийн 70 багшийг хамруулж чадавхжуулсан. Бага насны хүүхдийг ахуйн болон гэнэтийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, анхны тусламж үзүүлэх	100

					арга зүйн зөвлөгөө өгөх, өсвөр үеийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох сургалтад хүүхдийн байгууллагын 50 эмчийг хамруулсан.	
3.7	Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтэнд хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй тохиолдлыг таньж мэдэх, илрүүлэх, яаралтай болон анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх ур чадвар эзэмшүүлэх	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулсан байна.	-	-	Бага насны болон өсвөр насны хүүхдүүдийн дунд далд хүчирхийллийг илрүүлэх, таних, мэдээлэх, баримтжуулах сургалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран зохион байгуулж, хүчирхийллийг илрүүлэх, баримтжуулах, мэдээлэх талаар арга зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулж, Орхон аймгийн 17 Ерөнхий боловсролын сургуулийн 20 эмч, 19 нийгмийн ажилтан, 8 ӨЭМТ-ийн 68 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж, чадавхжуулсан.	70
3.8	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээнд хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламжийн багц үйлчилгээг нэвтрүүлж хэрэгжүүлэх	Эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээг тодорхойлсон байна.	-	-	8 өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар хамтарсан багийн 35 кейс тохиолдлын 74 иргэнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн бөгөөд үүнээс 69 буюу 93.2% нь хүүхэд байна. Сэтгэл зүйн анхан шатны тусламж үйлчилгээ шаардлагатай 12 хүүхэд, эмэгтэйчүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн байна. Гэрээр хүмүүждэг, эмээ, өвөө дээрээ өсөж буй, асран хамгаалагч нь хөгжлийн бэрхшээлтэй, эцэг эх нь архины хамааралтай зорилтот бүлгийн 3-16 насны 253 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулж, сэргээн засах эмчилгээнд 41 хүүхэд, өдрийн эмчилгээнд 100 хүүхдийг хамруулж, 30 хүүхдэд витаминь багцыг олгож, гэртээ хүүхдээ хардаг зорилтот бүлгийн 13 ахмадад сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Гэрийн эргэлт, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоогоор эрсдэлт нөхцөлд буй эрх нь зөрчигдсөн 12 хүүхдийг илрүүлж мэдээлсэн. 2025 оны 11 сарын байдлаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад жирэмсний хяналтад шинээр 1453 эх хамрагдсан байна. ЭМС-ын 2024 оны А/292 дугаар тушаалын дагуу жирэмсний хяналтын үзлэгийн явцад 3 удаа хүчирхийллийн асуумж авч үнэлдэг. Тайлант хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн асуумжтай, гэрийн төрөлтийн 1 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд харьяалах өрхийн эрүүл мэндийн төв ГБХЗГ-тай	80

					хамтран, хамтарсан үнэлгээ өрхийн эрүүл мэндийн төв нярайг долоо хоног бүр эргэж, хоол хүнс, амжиргааны тусламж үзүүлсэн. Булган аймгийн харьяа өсвөр насны жирэмсэн, хүчирхийллийн асуумж эерэг 1 тохиолдлыг харьяалах ЭМГ, ЭМТ-д мэдээлсэн.	
3.9	Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад нийгэм сэтгэц-зан үйлийн тусламж үзүүлэх арга барилд сургах	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилчдад сургалт зохион байгуулсан байна.	-	-	- “Стресс менежмент”, “Ажлаас халшрах хам шинжээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ”, “Миний мэргэжил миний бахархал”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх”, “Тамхины хор нөлөө - хэрэглэхээс татгалзах нь”, “Тамхины тухай хууль”, “Стрессийг эерэгээр даван туулах нь, Зөөлөн ур чадвар, Байгууллагын соёлын өөрчлөлт ажилтны оролцоо, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, Сэтгэцийн эрүүл мэнд гэж юу вэ?” сэдвээр 12 удаагийн сургалтыг зохион байгуулж Бүсийн оношилгоо эмчилгээний төвд шинээр орж байгаа эмч, мэргэжилтнүүд, Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, Баян-Өндөр мед эмнэлгийн эмч, мэргэжилтнүүд давхардсан тоогоор 491 хүн хамрагдсан. 2 байгууллагатай хамтран сум, өрхийн эмнэлгийн эмч мэргэжилтнүүдэд “Амиа хорлох оролдлого хийсэн хүүхэд өсвөр үеийнхэнд сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх заавар батлах тухай” ЭМС-ын А\149-р тоот тушаалыг танилцуулж, арга зүйгээр хангаж ажилласан.	90
Зорилт 4. Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар иргэд, олон нийтэд сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;						
4.1	Хүүхдийн эсрэг үйлдэгдэх хүчирхийллийн бүх хэлбэрийг таслан зогсоох, хүчирхийллээс сэргийлэх ажлыг зохион байгуулах	Хүчирхийллээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	-	-	Хүүхдийн далд хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг илрүүлэх, баримтжуулах, хамгаалах үйлчилгээ үзүүлэх, сургалтыг 1 удаа зохион байгуулж 51 өрхийн эмч, ерөнхий боловсролын сургуулийн эмч, нийгмийн ажилтныг хамруулсан. Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр БГ,ХГБХГ,ЦГ-тай хамтран “Өсвөр үеийнхнийг ойлгоё, сонсьё” аяныг зохион байгуулж, 6 төрлийн үйл ажиллагаа, 69 удаагийн сургалт, 1 удаагийн хэлэлцүүлэг, 16 удаагийн өдөрлөгт 19 сургуулийн 5-12 дугаар ангийн 3013 хүүхдэд зохион байгуулж, эрүүл мэндийн зөвлөмж бүхий 2-5 төрлийн 3155 гарын	100

					авлагыг түгээж ЭМБ-ыг олон талт байдлаар олгож, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж ажилласан. - Баянцагаан багийн хамтарсан багтай хамтран “Анзааръя-Анхааръя” аяны хүрээнд “Өсвөр насны хүүхдийн сэтгэл зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж ЕБ-ийн дунд болон ахлах ангийн сурагчдын 100 эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулан өсвөр насны хүүхдийн сэтгэлзүйн чиглэлээр эцэг эхийн мэдлэг боловсролыг сайжруулсан. -Өсвөр насны охидын жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг зохион байгуулж, 552 охидыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан 33 хүүхдийг эмчийн хяналтад авсан. ЭМГ-ын цахим хуудсаар хүүхэд, өсвөр үеийн чиглэлээр 41 постер, 10 видео шторк нийт 51 мэдээллийг байршуулж давхардсан тоогоор 126762 иргэнд түгээсэн. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 2 сэтгэл зүйчтэй хамтран 4 өдрийн хугацаанд “Найрамдлын эрдэнэс” зусланд ажиллаж, амарч байсан хүүхдүүд, эцэг эхчүүд нийт 222 хүнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлж ажилласан. Үүнд: Хоолны хордлогын шинжтэй хэвтэн эмчлүүлж байгаа 198 хүн (89.1%) буюу 11 том хүн (5.5%), 187 хүүхэдтэй (94.5%) уулзаж ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Гадуур, гэртээ байгаа хүүхдүүдийн 24 эцэг эхчүүдэд цахимаар зөвлөгөө өгч ажилласан.	
4.2	Түр хамгаалах байр, хүүхдийн байгууллагад ажиллаж буй багш, ажилчдад хохирогчтой хэрхэн зөв харьцах чадамж эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байна.	-	-	-Сэтгэцийн эрүүл мэндийн Дэлхийн өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан “Гамшгийн үеийн сэтгэл зүй”, “Уй гашууг даван туулах нь”, “Стресс менежмент” сургалтад сэтгэл зүйч, нийгмийн ажилтан эмч нар нийт 78 мэргэжилтнийг хамруулсан.	70
4.3	Багш, сурган хүмүүжүүлэгч нарт жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид байх сургалтыг зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байна.	-	-	- БГ, ХГБХХГ-тай хамтран "Сайн туршлага" түгээн дэлгэрүүлэх, хүчирхийллийг илрүүлэх, “Өсвөр үеийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох” сургалтыг 2 удаа зохион байгуулж ерөнхий боловсролын 19 сургуулийн 109 эмч, багш, нийгмийн ажилтыг хамруулж тэдний мдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн.	70

4.4	Хүчирхийллийн хохирогч болох нэн ялангуяа хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг ойлголтыг дээшлүүлэх олон нийтэд чиглэсэн ажлыг зохион байгуулах	Урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	-	-	Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас Улсын хэмжээнд зохион байгуулж буй “Анзаар-2” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Мансууруулах бодис, түүнээс урьдчилан сэргийлэх” сургалтыг 8 удаа зохион байгуулж 12 байгууллагын 2400 албан хаагчид болон сургуулийн ахлах ангийн хүүхдүүд, эцэг эхчүүдийг хамруулсан. - Үеийнхээ найз нөхдийг бүү дээрэлхээрэй, бусдын эд зүйлийг хулгайлах хориотой, дээрэлхэлт гэж юу вэ сэдвийн хүрээнд хүүхэд бүрийн сонирхол, онцлог хэрэгцээнд нь тулгуурлан сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цахим хуудсаар мэдээллийг тогтмол хүргэж ажиллаж байна. - Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран "Цахимд өнгөрүүлж буй цагаа өөрт хэрэгцээт мэдээллээ олж авахад ашиглая, мэдсэн сурснаа бусадтай хуваалцдаг байя" уриатай “Өсвөр насны хүүхдүүдийн дунд тулгамдаж буй асуудал болж буй электрон тамхи эрүүл мэндэд учруулах хор уршиг, нөлөөлөл”-ийн талаар ярилцсан “ХЭРЭГТЭЙ ХОВ” подкаст хийж цахимаар түгээсэн. - “Хордохоос татгалзъя” нөлөөллийн аянд төрийн байгууллагууд, ААНБ-ууд болон ЕБС-ийн сурагчдыг хамрагдаж ажилласан. - Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийнхан болон политехник коллежийн оюутнуудад ялгаварлан гадуурхах, дээрэлхэх, мансуурах зэрэг хорт зан үлээс сэргийлэх, хор уршгийн сургалтуудыг зохион байгуулж 1952 өсвөр үеийнхэн хамрагдсан	90
4.5	Шинээр гэр бүл болж буй залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, жендерт суурилсан хүчирхийллээс ангид байх, МСС, нөлөөллийн ажил явуулах	Эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн шинэ, залуу гэр бүлд ЖСХ-ээс ангид байх сургалт зохион байгуулах	-	-	Аймгийн хэмжээнд нөхөн үржихүйн насны 24.027 эмэгтэй байгаа ба тайлант хугацаанд гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгсэлд 16,297 буюу 67.8%-д хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 1,2%-иар нэмэгдсэн байна. Нөхөн үржихүйн насны 25,030 эмэгтэйчүүдийн 14,626 буюу 58.4%-ийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12,1%-иар нэмэгдсэн байна. Гэр бүлийн боловсрол олгох сургагч багшийн “Гэр бүлийн эрүүл мэндийн боловсрол” 8 цагийн сургалтыг	70

					Боловсролын газартай хамтран сургуулийн өмнөх боловсролын 24 багшид “Хүүхдийн шүдний эрүүл мэнд, шүд угаах арга” сэдвээр сургалт зэрэг 3 удаагийн сургагч багш бэлтгэх сургалтад 81 байгууллагын 174 хүнийг хамруулан мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн.	
4.6	Сургуулийн орчинд үйлдэгдсэн хүчирхийлэл, дарамтад өртсөнийг илрүүлэх, мэдээлэх талаар сургуулийн багш, нийгмийн ажилтан, эмч нарт танилцуулах	Сургалт зохион байгуулсан байна.	-	-	БГ-тай хамтран "Сайн туршлага" түгээн дэлгэрүүлэх сургалтын хүрээнд “Өсвөр үеийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох” сургалтыг зохион байгуулж анги удирдсан 70 багшийг хамруулж, өсвөр үеийнхний эрүүл мэнд, анхаарах асуудлууд болон нөхөн үржихүй, бэлгийн боловсролын талаар мэдлэг олгож тэдний эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хандлагыг нэмэгдүүлсэн. Бага насны болон өсвөр насны хүүхдүүдийн дунд далд хүчирхийллийг илрүүлэх, таних, мэдээлэх, баримтжуулах сургалтыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газартай хамтран зохион байгуулж, хүчирхийллийг илрүүлэх талаар арга зүйн зөвлөмж мэдээлэл өгч, хүүхэд хамгааллын тухай хууль, эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгаалал болон холбогдох журмыг танилцуулсан. Тус сургалтад Орхон аймгийн 17 Ерөнхий боловсролын сургуулийн 20 эмч, 19 нийгмийн ажилтныг хамруулж, чадавхжуулсан.	70
4.7	Хот, суурин газарт шилжин суурьшигчдад гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийллийн талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх эрүүл мэндийн боловсрол олгох	Шилжин ирж буй цэргийн албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.	-	-	-СЭМҮТ, "Ногоон хүрээлэнгийн багш нар" НҮТББ-тай хамтран "Сэтгэцийн эрүүл мэнд, архи, тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх нь" сургалтыг Дотоодын цэргийн 50 албан хаагчдын дунд зохион байгуулсан. - Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр жирэмсэн эх, гэр бүл, олон нийтэд чиглэсэн Эрүүл эхээс - Эрүүл хүүхэд" уриатай "Амьдралын алтан 1000 хоног" сургалтыг “Тогтвортой хөгжил ирээдүй” төрийн бус байгууллагатай хамтран эрүүл мэндийн боловсрол олгох өдөрлөг, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг 8 удаа зохион байгуулж 390 жирэмсэн эх, түүний гэр бүлийг хамруулж 2 төрлийн 395 ширхэг гарын авлагыг түгээж ажилласан. Тус сургалтаар Амьдралын эхний 1000 хоногийн хугацаанд хүүхдийн өсөлт, хөгжлийг дэмжих, хянах, эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргааны талаар эцэг, эх асран хамгаалагчдын	70

					эрүүл мэндийн боловсрол дээшилсэн. -“Алтан 1000 хоног” нэртэй фэйсбүүк группыг нээж сургалтад хамрагдсан ээжүүдийг урьж оруулан ээжүүд болон тэдний гэр бүлийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгохоор нарийн мэргэжлийн эмч, сэтгэлзүйчийн ярилцлага, мэдээлэл зөвлөмж бүхий 6 төрлийн видеог бэлтгэж, байршуулан нийт 7690 иргэнд эрүүл мэндийн мэдээлэл түгээж ажилласан байна. - Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт болон халдварт бус өвчнийг эрт үед нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх, мөн цэргийн жинхэнэ албанд татагдах иргэдийн эрүүл мэндийн үзлэгийг чанартай, нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх зорилгоор Засаг даргын А/779 дүгээр захирамжаар ээлжит цэрэг татлагын урьдчилан сэргийлэх үзлэгийг 4 хоногийн хугацаанд 18 төрлийн үзлэг шинжилгээ оношилгоонд 27 багийн 321 цэргийн насны залуучуудыг хамруулан ажилласан.	
Хэрэгжилтийн дундаж хувь-83,9% (тодорхой үр дүнд хүрсэн)						

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХҮҮХЭД ӨСВӨР ҮЕ,ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ЦЭРЭНЛХАМ

ХЯНАЛТ –ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

П.ХИШГЭЭ